



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 172 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 6,942,800 /зургаан сая есөн зуун дөчин хоёр мянга найман зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг /З.Болормаа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 10 нэр төрлийн 6,942,800 /зургаан сая есөн зуун дөчин хоёр мянга найман зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг /З.Болормаа/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000105
Тушаал 2021

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2021 оны 03 дугаар сарын 16 өдрийн
... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 172 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Зөөврийн компьютер	9	ш	1	1,399,000.00	1,399,000.00	1,399,000.00	-	Шатсан	Актлах	Татах
2	Өнгөт принтер Brother	9	ш	2	400,000.00	800,000.00	800,000.00	-	Эвдэрхий	Актлах	Татах
3	Зөөврийн компьютер	8	ш	1	1,279,000.00	1,279,000.00	1,279,000.00	-	Шатсан	Актлах	Татах
4	Зургийн аппарат	7	ш	1	299,900.00	299,900.00	299,900.00	-	Эвдэрхий	Актлах	Татах
5	Хяналтын камер /дотор/	7	ш	8	85,000.00	680,000.00	680,000.00	-	Шаардлага хангахаа больсон	Актлах	Татах
6	Хяналтын камер /гадна/	7	ш	2	165,000.00	330,000.00	330,000.00	-	Шаардлага хангахаа больсон	Актлах	Татах
7	Төв сервер 24 оролттой	7	ш	1	990,000.00	990,000.00	990,000.00	-	Шаардлага хангахаа больсон	Актлах	Татах
8	Угаалгын машин Media	7	ш	1	479,900.00	479,900.00	479,900.00	-	Мотор шатсан	Актлах	Татах
9	Ус цэвэршүүлэгч	4	ш	1	185,000.00	185,000.00	185,000.00	-	Эвдэрхий	Актлах	Татах
10	Дэлгэц	7	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-	Шатсан	Актлах	Татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				19	-	6,942,800.00	6,942,800.00	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				19	-	6,942,800.00	6,942,800.00	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө				19	-	6,942,800.00	6,942,800.00	-			
Актлах хөрөнгө				-	-	-	-	-			0